

БҮЛЭГ АЗ: АРГА ЗҮЙ

АГУУЛГА

3. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	2
3.1 ОРШИЛ.....	2
3.2 БОННБУ БОЛОВСРУУЛСАН АРГА БАРИЛ.....	2
3.2.1 Оюу Толгой төслийн хүрээнд өмнө нь хийгдсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ).....	3
3.2.2 Оюу Толгой төслийн өмнө нь хийгдэж байсан Нийгэм, эдийн засгийн судалгаанууд ..	5
3.3 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭнд тавигдах шаардлагууд	6
3.3.1 Монгол улсын хуулийн шаардлагууд.....	6
3.3.2 Төслийн санхүүжилтийн шаардлага	8
3.3.3 Олон Улсын Санхүүгийн Корпорацийн шаардлага	8
3.3.4 Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны шаардлага	8
3.3.5 Экваторын зарчим	9
3.4 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭний гол үе шатууд	9
3.4.1 БОННБУ-ний анхан шатны үнэлгээ	9
3.4.2 Судалгаа ба урьдчилсан хэлэлцүүлэг	9
3.4.3 Байгаль орчны суурь мэдээллийн эмхтгэл	10
3.4.4 Нийгмийн суурь мэдээллийн эмхтгэл	11
3.4.5 Нөлөөллийн ангилал ба зэрэглэл	11
3.4.6 Бууруулах арга хэмжээ болон хяналт шинжилгээний төлөвлөлт.....	12
3.4.7 Байгаль орчин ба нийгмийн менежментийн систем	12
3.4.8 Нөхөн сэргээлт ба уурхайн хаалт	12
3.5 ХУРИМТЛАГДАХ НӨЛӨӨлөл	13

Зургийн жагсаалт

Зураг 3.1: Монгол улсын Байгаль орчны үнэлгээний зөвшөөрөл олголтын үйл ажиллагаа	7
---	---

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 3.1: Оюу Толгой төслийн өмнөх БОНБНУ-нүүд	3
Хүснэгт 3.2: Оюу Толгой төслийн нэмэлт байгаль орчны судалгаанууд болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнүүд	4

3. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

3.1 ОРШИЛ

Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОННБҮ) энэ бүлэгт Монгол улсын Оюу Толгойн зэс, алтны төслийн БОННБҮ-г бэлтгэх ерөнхий арга замуудын талаар авч үзнэ. Мөн энэ бүлэг нь БОННБҮ-ий үндэслэл, хууль эрхзүйн, байгууллагын болон төслийн цар хүрээг тодорхойлох, олон нийтийн хэлэлцүүлэг хийх, нөлөөллийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хэрхэн сонгосон зэрэг энэхүү БОННБҮ-г боловсруулахад хэрэглэсэн гол арга барилын талаар өгүүлнэ.

3.2 БОННБҮ БОЛОВСРУУЛСАН АРГА БАРИЛ

Оюу Толгойн Байгаль Орчин, Нийгэмд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ /БОННБҮ/-г Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 он), Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (1998, 2001 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан), Ашигт малтмалын тухай хууль (2006 он) зэрэг хуулиудын шаардлагуудыг хангахуйц холбогдох зөвшөөрлүүдийг авах болон төслийн төлөвлөлтийг боловсруулах зорилгоор хийгдсэн олон тооны судалгааны тайлангууд, Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээ /БОННБҮ/-үүд зэрэгт үндэслэн боловсруулсан юм. (Эдгээр хуулиудын талаарх дэлгэрэнгүй мэдээллүүд энэхүү БОННБҮ-ний Бүлэг А2: Бодлого ба Хууль эрхзүйн хүрээнд тусгагдсан.) Эхний ээлжийн БОННБҮ-үүдийг “Эко Трейд” ХХК нь 6 жилийн хугацаанд буюу 2002-2008 онуудад төсөлд зориулан хийж гүйцэтгэсэн байна.

БОННБҮ -ний хүрээнд хийгдсэн ажлуудыг энэхүү БОННБҮ-г боловсруулахад гол суурь болгон ашигласан. Төслийн төлөвлөлт нь байнга шинэчлэгдэн дахин боловсруулагдаж байсантай холбогдуулан олон тооны нэмэлт судалгаануудыг хийхсэн юм. Эхний БОННБҮ-үүд нийгмийн болон байгаль орчны асуудлуудын суурь мэдээллэлийг хангасан ба энэхүү БОННБҮ-нп эдгээрүүдийг сүүлийн үеийн хичналт шалгалт, судалгааны үр дүнгүүд, нийгмийн нэмэлт дүн шинжилгээ болон Оюу Толгой төслийн Нийгэм, Эдийн Засгийн Суурь Судалгааны¹ ашиглалт ба Нийгэмд Нөлөөлөх Байдлын Үнэлгээний тайлан² боловсруулалт зэрэг мэдээллүүдээр баяжуулж өгсөн.

Эхний ээлжийн БОННБҮ-дийг техникийн хянан магадлагаа хийхэд амар байх зорилгоор төслийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт нөлөөллийн үнэлгээ хийх Монгол улсын Засгийн газрын шаардлагын дагуу боловсруулагдсан юм. Тэдгээр БОННБҮ-үүдийг батлагдсанаас хойш Монгол улсын Засгийн газраас төслийн сүүлийн төлөвлөлтөнд тусгасан нийт төслийн хэмжээний нөлөөлөл болон түүнийг бууруулах арга хэмжээний цогц Байгаль Орчин Нийгэмд Нөлөөлөх Байдлын Үнэлгээг (энэхүү тайлан) хийлгэх хүсэлтийг Оюу Толгой ХХК-д тавьсан юм.

Тэдгээр БОННБҮ-үүдыг бүтэц, агуулгын хувьд Монгол улсын стандартад нийцүүлэн хийсэн. Хэдийгээр эдгээр үнэлгээнүүд нь Дэлхийн Банк ба Олон Улсын Санхүүгийн Корпорацийн заавар удирдамжийг харгалзан боловсруулсан боловч Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Нийгэм, байгаль орчны тогтвортой байдал ба Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкны Байгаль орчин, нийгмийн бодлого зэргийг бүрэн хамарсан олон улсын санхүүгийн байгууллагуудын бодлогуудын дэлгэрэнгүй тусгаагүй юм. Жишээлбэл, тэдгээр БОННБҮ-үүд нь нийгэм болон олон нийтийн асуудлуудыг өргөн хүрээнд авч үзээгүй. Тиймээс энэхүү БОННБҮ нь Монгол улсын засгийн газрын (хуулийн) шаардлагын дагуу ОУСК-ийн тэргүүлэх туршлаганд нийцүүлэн нийгмийн асуудлуудад анхаарлаа хандуулсан юм.

Энэхүү БОННБҮ-г өмнө нь Оюу Толгой төслийн хүрээнд хийгдсэн БОННБҮ-үүд, төслийн Нийгэмд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ болон бусад судалгаануудын тохиромжтой гэсэн хэсгүүдийн түүврийн нийлмэл маягаар бэлтгэсэн юм. Энэхүү тайланд өмнө нь хийгдсэн бүх судалгаанууд болон олон нийт, ард иргэдтэй хийсэн хэлэлцүүлгүүд ба оролцооны үйл ажиллагаануудыг олон улсын тэргүүний туршлаганд нийцэж буйг харуулан тусгасан байгаа.

¹ Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа (дэд багц), Бодлого Судлалын Төв, Хүн амын Сургалт, Судалгааны Төв, Улаанбаатар хот Монгол улс, 2009 оны 9-р сар

² Оюу Толгой төслийн Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ, Эцсийн тайлан, Бодлого Судлалын Төв, Хүн амын Сургалт, Судалгааны Төв, Улаанбаатар хот Монгол улс. 2009 оны 9-р сар

Өмнө нь хийгдсэн судалгаануудын үр дүнг энэхүү тайланд зохих хэмжээгээр тусгах буюу ишлэн оруулж өгсөн юм. Мөн түүнчлэн олон нийттэй хийсэн хэлэлцүүлэг ба оролцогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагаануудыг олон улсын тэргүүлэх туршлага болон зээлдүүлэгчдийн шаардлагуудад нийцүүлэн тусгаж өгсөн.

3.2.1 Оюу Толгой төслийн хүрээнд өмнө нь хийгдсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБҮ)

Оюу Толгой төслийн хүрээнд өмнө нь хийгдсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнүүдийг *Хүснэгт 3.1-д* нэгтгэн харуулав.

Хүснэгт 3.1: Оюу Толгой төслийн өмнөх БОНБҮ-нүүд

Үнэлгээний нэр	Тайлбар	Огноо	Байр байдал
Оюу Толгой төслийн Байгаль орчны суурь судалгаа	Энэхүү судалгаа нь газарзүй, геологи, ус судлал, гидрогеологи, хөрс, цаг уур, агаарын чанар, ургамал, амьтан, Оюу Толгой төслийн бүс нутаг болон түүний эргэн тойрны газар нутгийн нийгэм, эдийн засгийн болон дэд бүтцийн байдал зэргийг хамрасан.	2002 оны 11-р сар	Уг судалгааг 2002 оны 11-р сард БОНБҮ болгон БОАЖЯ-нд өргөн барьсан. Суурь судалгаанд Ерөнхий Үнэлгээний Дүгнэлт (ЕҮД) гаргуулах шаардлагагүй байдаг.
Төслийн БОНБҮ <i>Боть 1:</i> Оюу Толгой –Гашуун Сухайтын тээвэр ба дэд бүтцийн зурвас	Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүрэх баруун талын авто зам ба эрчим хүчний шугамд хийгдсэн БОНБҮ. <i>Бүлэг А5-ын Зураг 5.6-г</i> харна уу. Өмнийн Говийн дархан цаазат газраар дайран өнгөрөх зөвшөөрлийг авсан.	2004 оны 4-р сар	2004 оны 5-р сард батлагдсан.
Төслийн БОНБҮ-ний нэмэлт тодотгол, <i>Боть 1:</i> Оюу Толгой – Гашуун Сухайтын тээвэр ба дэд бүтцийн зурвасын маршрутын өөрчлөлт	Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүрэх зүүн талын шинэ маршрутад хийгдсэн үнэлгээ бөгөөд баруун талын маршрутын ойролцоох газар нутагт нүүрс тээвэрлэдэг машинуудын замын хөдөлгөөнөөс үүссэн байгаль орчны эвдрэлийн үнэлгээг мөн багтаасан. <i>Бүлэг А5-ын Зураг 5.6-г</i> харна уу.	2006 оны 12-р сар	2007 оны 3-р сард батлагдсан.
Оюу Толгой төслийн БОНБҮ-ний <i>Боть 2:</i> Гүний Хоолой, Галбын Говын гүний усны уст давхаргын бүсийн усан хангамж	Оюу Толгой төслийн усан хангамжийг тогтвортой байлгах зорилгоор боломжит уст давхаргуудын нөөцүүдэд үнэлгээ хийсэн.	2005 оны 6-р сар	2005 оны 9-р сард батлагдсан.
БОНБҮ-ний нэмэлт тодотгол, <i>Боть 2:</i> Гүний Хоолой, Галбын говийн гүний усны уст давхаргын бүсийн БОНБҮ	2005 онд батлагдсан БОНБҮ-ний <i>Боть 2-т</i> хийгдсэн шинэчлэлт юм. Төслийн усны хэрэгцээ нэмэгдсэнтэй холбогдуулан Гүний Хоолой бүсийн боломжит нөлөөлөл ба эрсдлүүдийг шинэчлэн үнэлэн гүний усны хяналт шинжилгээг сайжруулсан.	2010 оны 12-р сар	БОАЖЯ-ны ЕҮД 2009 оны 12 сард гарсан. Эцсийн хяналт ба зөвшөөрлийг БОАЖЯ ба УХЭГ 2011 оны 3-р сард өгсөн.
БОНБҮ-ний нэмэлт тодотгол, <i>Боть 2:</i> Гүний Хоолойн цооногийн талбайн ус дамжуулах хоолойн шугам ба холбогдох дэд бүтэц	2008 оны 12-р сард Инженерийн тайлан дээр үндэслэн шинэчлэгдсэн. Энэ тайлан нь Гүний Хоолойн усны цооногийн талбайгаас ОТ уурхай хүртэлх ус дамжуулах хоолойн шугам, худаг, усны шахуурга, усан сан, усны цөөрөм, эрчим хүчний хангамж, ба зам зэрэг хамарсан.	2009 оны 12-р сар	2008 онд анхны хувилбар нь гарсан. 2009 оны 12-р сард шинэчлэгдэж, 2010 оны 3-р сард батлагдсан.

Үнэлгээний нэр	Тайлбар	Огноо	Байр байдал
Оюу Толгой төслийн БОНБУ-ний Боть 3: Оюу Толгой уурхайн олборлолт ба үйлдвэрлэлийн байгууламжууд	БОНБУ нь Оюу Толгой төслийн уурхайн лицензит талбай дотор байрлах ил болон далд уурхай, баяжуулах үйлдвэр, хаягдлын байгууламж болон бусад туслах дэд бүтцийг хамарч хийгдсэн. Энэ үнэлгээ нь 2005 онд хийгдсэн Хөгжлийн Цогц Төлөвлөгөөнд үндэслэгдсэн хэдий ч 2006 оны 5-р сарын төлөвлөлтийн ерөнхий тоймыг мөн тусгасан. Үйлдвэрлийн хүчин чадал нь өдөрт 85,000 тонн байхаар төлөвлөн хийгдсэн.	2006 оны 5-р сар	2007 оны 12-р сард батлагдсан
Оюу Толгой төслийн БОНБУ-ний Боть 4: Нүүрсээр ажилладаг цахилгаан станц	3х100 МВт-н хүчин чадалтай цахилгаан станцын БОНБУ . (2006 он)	2006 он	Техникийн хураангуйн төсөл ба БОНБНУ нь хийгдсэн боловч батлагдаагүй.
Оюу Толгой төслийн БОНБУ-ний Боть 5: Орон нутгийн нисэх онгоцны буудлын нүүлгэн шилжүүлэлт	Оюу Толгой төслийн уурхайн лицензит талбайгаас хойш 10 км зайд 2000м онгоцны нисэх/буух зурвас зам, аюулгүйн зурвас, нисэх онгоцны зогсоол, хяналтын цамхаг, зорчигчдын дамжин өнгөрөх байр, машины зогсоол, 15х15м хүлээлгийн заал, нисэх/буух зурвасын гэрэлтүүлэг, 40кВА-н эрчим хүчний хангамж, гадаргуунус зайлуулах систем, хашаа зэргээс бүрдэх түр хайрган нисэх буудал байгуулах төсөл юм. Энэ БОНБУ-нд шинэ нисэх буудлын барилга ба ашиглалтын үйл ажиллагаа багтсан. Энэ байгууламж нь түр ба байнгын нисэх буудал болгон шинэчлэгдэх юм.	2007 оны 6-р сар	2007 оны 9-р сард батлагдсан.
Байнгын нисэх буудлын Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ	Байнгын нисэх буудлын барилгын ажил ба үйл ажиллагааны БОНБУ	2011 он	2011 онд батлагдсан
Умдай голын голдирол өөрчлөлтийн Байгаль орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээ	Умдай голын голдирол өөрчлөлтийн БОНБУ	2011 он	БОАЖЯ-наас зөвшөөрөл хүлээж байгаа (2012 оны 1-р сарын байдлаар)

Төслийн бүрэн хэмжээний БОНБНУ хийлгэх шаардлагагүй ч дүрэм журмын дагуу зохих зөвшөөрөл авахын шаардлагатай онцлог бүрэлдэхүүн хэсгүүдийн нэмэлт байгаль орчны судалгаануудыг хийсэн юм. Эдгээр судалгаануудыг доорх хүснэгтэд нэгтгэж үзүүлэв.

Хүснэгт 3.2: Оюу Толгой төслийн нэмэлт байгаль орчны судалгаанууд болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнүүд

Төслийн БОНБУ хийгдсэн бүрдэл хэсгүүд	Тайлбар	Огноо	Байр байдал
Оюу Толгой уурхай дээрх Петровисын түр ШТС-ийн байгууламж	Уурхайн лицензит талбай дотор 2004 байгуулагдсан ШТС-д хийгдэж дууссан	2005 он	2005 онд батлагдсан
Оюу Толгойн шатахууны агуулах байр ба ШТС	ШТС-г 2008 онд өргөжүүлэн шатахуун агуулах шинэ байр барьсан. ШТС нь 2 га талбайтай, А-92, А-80 бензиний 25м ³ багтаамжтай хагас булсан 4ш танктай, дизелийн 50м ³ багтаамжтай 10ш танктай, 2 түгээх станцтай.	2010 оны 1-р сар	2010 оны 2-р сарын18-нд БОАЖЯ-нд өргөн барьж, 2010 оны 9-р сарын13-нд

Төслийн БОНБҮ хийгдсэн бүрдэл хэсгүүд	Тайлбар	Огноо	Байр байдал
			батлагдсан.
1-р босоо ам	Босоо ам, дээрх копёрийн байгууламжууд, хаягдал чулуулаг ба бохир усны зайлуулалт зэргийг хамарч хийгдсэн БОНБҮ.	2005 он	2005 оны 6-р сард батлагдсан
2-р босоо ам	Босоо ам, дээрх копёрын байгууламжууд, хаягдал чулуулаг ба бохир усны зайлуулалт зэргийг хамарч хийгдсэн БОНБҮ.	2006 он	2007 оны 12-р сард батлагдсан
Бохир ус цэвэршүүлэх байгууламж	4000 хүн байршуулах хүчин чадалтай барилгын кэмийн хэрэглээний бохир усыг цэвэршүүлэх байгууламжийн нэмэлт БОНБҮ	2007 оны 2-р сар	2007 оны 5-р сард батлагдсан
Бетон зуурмагын үйлдвэр ба Хайрганы уурхай	Оюу Толгой уурхайн лицензит талбайн хойд захад байрлах хайрганы ил уурхай, бетон зуурмагийн үйлдвэр, бутлуур зэргийн БОНБҮ.	2007 оны 3-р сар	2007 оны 4-р сард батлагдсан
20 МВт-н дизель цахилгаан станц	6х2МВт-ын дизелийн цахилгаан станцын эхний хувилбарын үнэлгээ ба 2-р үе шатны 4х2МВт-ын дизель генераторууд нэмэгдсэн юм.	2007 оны 7-р сар	2007 оны 9-р сард батлагдсан
Химийн бодисууд	Барилга ба бүтээн байгуулалтад ашиглагдах химийн бодисуудын импорт ба хэрэглээтэй холбоотой БОНБНҮ юм.	2008 оны 4-р сар	2008 оны 4-р сард батлагдсан

3.2.2 Оюу Толгой төслийн өмнө нь хийгдэж байсан Нийгэм, эдийн засгийн судалгаанууд

Нийгэм – Эдийн засгийн хэтийн төлвүүд монголын өмнөх БОНБНҮ-ний үйл ажиллагааны хүрээнд хамруулсан ба энэхүү судалгаа шинжилгээний БОНБНҮ нь Оюу Толгойн Олон Нийттэй Харилцах, Тогтвортой Хөгжлийн Хэлтэс (ОНХТХХ)-ийн хийсэн тайлан, судалгаануудаар өргөжүүлэн баяжуулсан юм. Гол судалгаануудыг доорх байдлаар үзүүлсэн ба *Боть* 2-т доорх жагсаалтыг бүрэн хэмжээгээр нь оруулсан :

- Оюу Толгой төслийн орон сууцны сонголтын дүн шинжилгээ ба Тактик 4, 2007 оны 11-р сар;
- Оюу Толгой төслийн хүн амын олноороо шилжин ирж суурьшилтын эрсдлийн дүн шинжилгээ, Барклай ба Ассосиатес, 2007-оны 10 сар;
- Оюу Толгойн төслийн Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчны дэд судалгаанууд, Эцсийн тайлан, Бодлого судлалын төв, Хүн амын сургалт судалгааны төв 2009 оны 9-р сар; Монгол улс, Улаанбаатар хот.
- Оюу Толгой төслийн Нийгэмд Нөлөөлөх байдлын Үнэлгээ, Эцсийн тайлан, Бодлого судлалын төв, Хүн амын сургалт судалгааны төв, Улаанбаатар хот, Монгол улс 2009 оны 9-р сар;
- Өмнөговь аймаг, Ханбогд сум, Баян багийн нутаг дэвсгэр дэх Гүний Хоолой орчмын бүс нутагт ОНХТХХ-ээс хийсэн “Малчдын усны уламжлалт зохицуулалт” жижиг хэмжээний судалгааны эмхтгэл; 2008 оны 7-9-р сар;
- ОНХТХХ-ээс хийсэн Гүний Хоолой орчмын нутаг дэвсгэрт бэлчээрийн газар ба усны хүртээмжийн одоогийн нөхцөл байдлын үнэлгээ – малчдын Гүний Хоолойн цооногийн талбайгаас ус авч ашиглах хүсэлтийг үнэлсэн судалгаа; 2009 оны 9-р сар; ба
- ОНХТХХ-ээс гаргасан 5 жилийн Нийгэм ба Эдийн засгийн менежментийн төлөвлөгөө, 2010 он.

3.3 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

Энэ хэсэгт байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой Монгол улсын болон олон улсын шаардлагуудын тоймлон үзүүлэв.

3.3.1 Монгол улсын хуулийн шаардлагууд

Байгаль орчны үнэлгээний талаарх холбоотой Монгол улсын гол хуулиуд нь:

- 1998 оны 1 сарын 22-нд батлагдан 2001 оны 11 сарын 22-нд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол улсын Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Үнэлгээний Тухай Хууль (БОНБҮ-ний тухай хууль); ба
- 2006 оны 7 сарын 8-нд батлагдсан Ашигт Малтмалын Тухай Хууль (Ашигт Малтмалын тухай хууль).

Монгол улсын Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Үнэлгээний Тухай хуульд шинэ төсөл хэрэгжүүлэх болон байгаа төслийг өргөжүүлэхийн тулд хийгдэх БОНБҮ-ний үйл ажиллагааг тогтоож өгсөн. Харин энэ хуульд нийгэмд нөлөөлөх байдлыг авч үзэх талаар заагдаагүй байдаг (ийм шаардлагыг тусган оруулж өгөх зохих нэмэлт өөрчлөлтүүд ойрын ирээдүйд хийгдэж магадгүй байгаа ч). Монгол улсын БОНБҮ-ний тухай хуулийн дагуу шинэ төслүүд болон төслийг өргөжүүлэхийн тулд эхлээд Төслийн тодорхойлолт, Техник эдийн засгийн үндэслэлээ Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ)-д өргөн барьж Ерөнхий үнэлгээ хийлгэх ёстой байдаг. Ерөнхий үнэлгээнээс дараах дүгнэлтүүд гарч болно:

- Төслийг хэрэгжүүлэхэд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагагүй;
- Тодорхой нөхцөл болзолтойгоор төслийг хэрэгжүүлж болно;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай; эсвэл
- Төсөл нь дараах үндэслэлүүдийн нэгний дагуу хүлээн зөвшөөрөгдөөгүй (i) хууль тогтоомжинд нийцээгүй, (ii) байгаль орчинд сөрөг нөлөөтэй (iii) мэдээлэл хангалтгүй байгаа.

БОНБҮ -ний тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

- Байгаль орчны суурь судалгаа;
- Төслийн тодорхойлолт болон хувилбарууд;
- Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг багасгах, бууруулах буюу их хэмжээний нөлөөллийг арилгах зөвлөмжүүд;
- Ослын эрсдлийн үнэлгээ;
- Байгаль орчны хамгаалалтын төлөвлөгөө (БОХТ);
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (БОХШХ);
- Иргэд болон засгийн газрын санал бодлыг тусгасан байх; ба
- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө болон төслийн талбайд биологийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө.

Ашигт малтмалын хууль нь БОНБҮ-д олон нийтийн эрүүл мэндийн асуудлыг тусгасан, уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хүн, амьтан, ургамал, агаар, усыг хамгаалах арга хэмжээг багтаасан Байгаль орчны хамгаалалтын төлөвлөгөөтэй байхыг шаарддаг. Нэн ялангуяа, Байгаль орчны хамгаалалтын төлөвлөгөөнд дараах зүйлсийг багтаасан байх ёстой:


- Хортой болон хортой байж болох бодисуудыг хадгалах, хянахад чиглэсэн арга хэмжээ;
- Газрын гадаргуу болон гүний усны нөөцлөлт, хамгаалалт, ашиглалтын арга хэмжээнүүд;
- Хаягдлын даланг байгуулалт ба уурхайн бүсийн аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээ;
- Уурхайн талбайн нөхөн сэргээлтийн арга хэмжээ; ба
- Уурхайн үйл ажиллагааны төрлөөс хамаарч хэрэгжүүлбэл зохих бусад арга хэмжээнүүд.

Байгаль орчны хамгаалалтын төлөвлөгөөнд тус төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарах байгаль орчны сөрөг нөлөөллүүдийн хяналт шинжилгээ болон бүртгэлийн талаар тусгасан байна. БОХТ-ний жилийн тайланг үндэсний болон бүс нутгийн захиргаанд хүргэнэ. Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг мөрдөж ажиллаж буйн баталгаа болгон уурхайн лиценз эзэмшигч нь Монгол улсын

БОАЖЯ-нд байгаль орчны хамгаалалтын жилийн төсвийнхөө 50%-ийн урьдчилгаа төлбөрийг байршуулдаг. Хэрэв уурхайн лиценз эзэмшигч нь байгаль орчны хамгаалалтын арга хэмжээг зохих ёсоор хэрэгжүүлээгүй бол засгийн газар уг урьдчилгаа төлбөрийг шаардлагатай арга хэмжээ авахад зарцуулна.

Доорх Зураг 3.1-д Монгол улсын Байгаль орчны үнэлгээний зөвшөөрөл олголтын үйл явцын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг дүрслэн харуулав.

Зураг 3.1: Монгол улсын Байгаль орчны үнэлгээний зөвшөөрөл олголтын үйл ажиллагаа



3.3.2 Төслийн санхүүжилтийн шаардлага

Энэхүү БОННБУ-г төслийн санхүүгийн боломжит зээлдүүлэгчдийн нийгэм, байгаль орчны үнэлгээний шаардлагуудыг хангахад ашиглана. Төсөлд холбоотой шаардлагууд:

- Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Гүйцэтгэлийн стандарт 1: Нийгэм, байгаль орчны үнэлгээ ба Менежментийн систем;
- Европын сэргээн босголт хөгжлийн банкны (ЕСБХБ) Гүйцэтгэлийн шаардлага 1; болон
- Экваторын зарчим 1, 2 ба 3

3.3.3 Олон Улсын Санхүүгийн Корпорацийн шаардлага

ОУСК-ийн Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын бодлогын дагуу тус корпораци нь санхүүжүүлж буй төслүүдээсээ хөгжлийн эерэг үр дүн гаргуулахыг эрмэлзэнэ гэж тэмдэглэсэн байдаг. Төслийн нийгэм, байгаль орчны тогтвортой байдал нь ийм эерэг үр дүнгийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх ба үүнд хүрэхийн тулд нийгэм, байгаль орчны өргөн хүрээтэй стандартуудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр Гүйцэтгэлийн стандартуудын эхнийх нь нийгэм, байгаль орчны үнэлгээнд хамааралтай.

ГС1: Нийгэм, байгаль орчны үнэлгээ ба менежментийн систем

ГС1 нь нийгмийн, байгаль орчны менежментийн давшингуй системийг төслийн хэрэгжих хугацааны туршид ашиглах замаар нийгэм ба байгаль орчны гүйцэтгэлийг удирдахын ач холбогдлыг цохон тэмдэглэдэг. Энэ гүйцэтгэлийн стандартын зорилтууд:

- Төслийн нөлөөллийн бүсэд үзүүлэх нийгэм, байгаль орчны эерэг ба сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон үнэлэх;
- Ажилчид, нөлөөлөлд өртсөн ард иргэд болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол багасгах, бууруулах, нөхөн төлбөр олгох;
- Нөлөөлөл үзүүлж болох асуудлуудыг шийдэхэд нөлөөлөлд өртсөн ард иргэдийг зохих ёсоор оролцуулах; ба
- Менежментийн системийг үр дүнтэй ашигласнаар компаниудын нийгэм, байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

3.3.4 Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны шаардлага

2008 оны Байгаль орчин, нийгмийн бодлогын дагуу, ЕСБХБ нь өөрийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон хяналт шинжилгээний үйл ажиллагаагаар дамжуулан тус банкнаас санхүүждэг төслүүд дараах шаардлагуудыг хангасан байх ёстой гэж үздэг. Үүнд:

- Нийгэм ба байгаль орчны хувьд тогтвортой байх;
- Нөлөөлөлд өртсөн ажилчид ба ард иргэдийн эрхийг хүндэтгэх; ба
- Хууль тогтоомжийн шаардлагууд болон олон улсын тэргүүлэх туршлагуудын дагуу төлөвлөгдөж, эдгээрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

Эдгээр зорилтуудаа ашиглаж амжилттай үр дүн гаргахын тулд, ЕСБХБ нь байгаль орчин, нийгмийн нөлөөллүүд ба асуудлуудын гол хүрээг хамарсан өргөн хүрээтэй Гүйцэтгэлийн шаардлагуудыг баталсан. ГШ1 нь нөлөөллийн үнэлгээнд хамааралтай:

ГШ 1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ ба Менежмент

Энэ гүйцэтгэлийн шаардлага нь Европын Холбооны байгаль орчны үнэлгээний зааврын (85/337/ЕЕС нэмэлт өөрчлөлт орсноор) дагуу төсөлтэй холбоотой үүсэх байгаль орчин, нийгмийн асуудлуудыг үнэлэх, удирдах ба хяналт шинжилгээ хийх үйл ажиллагаануудыг зааж өгдөг.

Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл ба асуудлуудыг “төслийн нөлөөллийн бүс” гэдэг талаас нь үнэлж авч үзэх нь чухал. Үүнд зөвхөн төсөл хэрэгжүүлэгчийн бүрэн хяналтад байгаа “Тухайн төсөл”-ийн төлөвлөлт, менежментээс гадна дагалдах барилга байгууламж ба бизнесүүд (жишээ нь гүйцэтгэгч), мөн хуримтлагдах нөлөөлөлд өртөж болох холбогдох байгууламж, бизнесүүд ба газар

нутаг буюу ард иргэд мөн хамрагдана³. Эдгээр байгууламж, бизнес, газар нутаг ба ард иргэдийн хувьд тулд тухайн төсөл хэрэгжүүлэгч нь ЕСБХБ-ны бодлого шаардлагыг дагаж мөрдүүлэхэд үзүүлэх өөрийн нөлөөллийг боломжийнхоо хирээр ихэсгэх хэрэгтэй юм.

ГШ 1-ийн гол бүрэлдэхүүн хэсгүүд:

- Төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн зэрэг ба сөрөг нөлөөллүүдийг тодорхойлох болон үнэлэх;
- Ажилчид, нөлөөлөлд өртсөн ард иргэд болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй бол багасгах, бууруулах, нөхөн төлбөр олгох арга хэмжээнүүдийг хэрэглэх;
- Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг сайжруулах боломжуудыг тодорхойлж, түүнийг ашиглах
- Гүйцэтгэлийн хяналт шинжилгээ ба үнэлгээний давшингуй үйл ажиллагаагаар дамжуулан байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн сайжруулалтыг дэмжих.

3.3.5 Экваторын зарчим

Төслийн санхүүгийн зээлдүүлэгчид нь Экваторын зарчимд гарын үсэг зурж нэгдсэн байх өндөр магадлалтай байдаг.

Экваторын зарчим нь (ЭЗ) төслийн санхүүжилтын нийгэм, байгаль орчны эрсдлийг тодорхойлох, үнэлэх ба удирдах стандартуудын иж бүрдэл юм.

ЭЗ 1. *Тойм ба ангилал* нь санхүүжүүлэхийг санал болгосон төслийг Олон улсын санхүүгийн корпорацийн байгаль орчин, нийгмийн үнэлгээний үзүүлэлтийн дагуу боломжит нөлөөлөл ба эрсдлийн ач холбогдол дээр үндэслэн ангилсан байхыг шаарддаг. ЭЗ 2. *Нийгэм, байгаль орчны үнэлгээ* нь А буюу Б ангилалд багтах төслийн хувьд нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, эрсдлээ Нийгэм, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх явцдаа тодорхойлсон байхыг шаарддаг. ЭЗ 3. Хэрэглэгдэх нийгэм, байгаль орчны стандартууд нь Олон улсын санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандартад хамаардаг ба үүнд ГШ1: *Нийгэм, байгаль орчны үнэлгээ болон менежментийн систем* багтдаг.

3.4 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ГОЛ ҮЕ ШАТУУД

3.4.1 БОННБҮ-ний анхан шатны үнэлгээний шалгалт

Олон улсын жишигт нийцсэн БОННБҮ-ний эхний үе шат нь (Экваторын зарчим 1 ба ОУСК болон ЕСБХБ-ны үнэлгээний шалгуурын дагуу) тухайн төслөөс үүсч болох байгаль орчны эрсдэлд үндэслэн “үнэлэх” буюу ангилал юм. Оюу Толгой төслийг А категори (өргөн цар хүрээтэй БОННБҮ-г хийх ёстой) гэж ангилсан ба Монгол улсын БОАЖЯ-ны журмын дагуу мөн Категори А гэж ангилагдсан.

3.4.2 Судалгаа ба урьдчилсан хэлэлцүүлэг

Судалгаа нь үнэлгээний үйл ажиллагааны хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэрээр ОУСК-ийн ГС1 ба ЕСБХБ-ны ГШ1 шаардлагуудад тусгагдсан байдаг. Монгол улсын үнэлгээний хууль тогтоомжийн зөвшөөрөл олголтын үйл явцын дагуу, БОАЖЯ нь Оюу Толгой төслийн БОННБҮ-ний гүйцэтгэгчээс “*БОННБҮ-г хийх явцдаа орон нутгийн оршин суугчдын санаа бодол болон саналуудыг авч, тайланд тусгах*”⁴ шаардлага тавьдаг.

Урьдчилсан хэлэлцүүлгүүд

³ Холбогдох байгууламж, бизнесүүд нь төслийн нэг хэсэг болон ЕСБХБ-аас санхүүждэггүй бие даасан хуулийн этгээд байж болох ч тэдгээрийн оршин тогтнох нь Төслөөс хамааралтай ба бараа үйлчилгээ нь төслийн тогтвортой ажиллагаанд нөлөөлдөг юм.

⁴ 1998 оны 1-р сарын 22-ны өдрийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль, 2001 оны 11-р сарын 22-нд шинэчлэгдсэн.

Төсөл нь 2003 оны 3-р сард урьдчилсан хэлэлцүүлэгүүдийг хийж эхэлсэн ба (БОАЖЯ-ны ЕҮД гарсны дараа) 2003 оны 7, 11-р саруудад үргэлжлүүлэн хийсэн.

2003 оны 3 ба 11-р саруудад болсон хэлэлцүүлгүүд нь орон нутгийн ард иргэд, УИХ-н Байнгын хороод зэрэг оролцогч талуудыг хамарсан. 2003 оны 7-р сард зохион байгуулагдсан хэлэлцүүлэг нь малчид буюу Ханбогд сумын оршин суугчдыг хамруулсан. Тэдгээр хэлэлцүүлэгт оролцогчид ерөнхийдөө тус төслийг дэмжиж байсан.

Орон нутгийн ард иргэд төслийн талаар тодорхой мэдээллүүдийг, тухайлбал ус, хөрс, бэлчээрийн газарт үзүүлэх нөлөөлөл, компанийн хөдөлмөрийн эрхлэлт, сургалт, болон ард иргэдэд туслах журмуудын талаар мэдээлэл авч байх сонирхлоо илэрхийлж байв. Тус төсөл нь хэрэгжих хугацааныхаа туршид байнга хэлэлцүүлэг хийж хэлэлцүүлгийн хөтөлбөрт ард иргэдийг оролцуулж байх юм.

Оюу Толгой ХХК нь хурал уулзалт болон хэлэлцүүлэгт хамрагдсан хувь хүн ба бүлгүүдийн мэдээллийг хэлэлцүүлгийн бүртгэлдээ нэгтгэн бүртгэдэг. Мөн энэ бүртгэлд хувь хүмүүстэй хийсэн хэлэлцүүлэг, олон нийтийн хурал, судалгааны үеэр тавигдсан асуулт ба хөндөгдсөн асуудлуудын нэгдсэн мэдээлэл болон Оюу Толгойн тэдгээрийг шийдэх зорилготойгоор авсан буюу авах арга хэмжээнүүдийг бүртгэдэг юм.

Судалгааны үйл ажиллагааны талаарх нарийвчилсан мэдээллийг *Бүлэг А6-д* тусгасан.

Нийгэмд нөлөөх байдлын үнэлгээний судалгааны хэлэлцүүлгүүд

Төслийн нийгэм, эдийн засгийн суурь судалгаа ба нөлөөллийн үнэлгээг 2008 – 2009 онуудад их хэмжээний хэлэлцүүлгүүдээр хийсэн байна. Хээрийн ажлын хүрээнд зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, бүлэг ба хувь хүмүүстэй ярилцлага хийх, холбогдох сумын эх сурвалж, удирдах ажилтнууд болон жилийн статистик мэдээнүүдээс хоёрдогч эх үүсвэрийн мэдээллийг цуглуулах зэрэг ажлууд хийгдсэн. Үнэлгээний нэг хэсэг болох оролцогч талуудын татан оролцуулах чиглэлээр дараах ажлууд хийгдсэн:

- Төслийн нөлөөллийн бүсэд орших 5 сумын 140 хүмүүсийн дунд хийсэн зорилтот бүлгийн хэлэлцүүлэг;
- Засаг захиргааны ажилтнууд, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтнууд зэрэгтэй хийсэн 70 албан бус ярилцлагууд; ба
- Боломжит нөлөөлөл, санаа зовоосон асуудлууд болон нөлөөлөл бууруулах урьдчилсан бодлогуудыг хэлэлцэх хурлууд.

3.4.3 Байгаль орчны суурь мэдээллийн эмхтгэл

Суурь мэдээллүүдийг доорх зүйлсийг хослуулах байдлаар цуглуулсан:

- Олон нийтийн нээлттэй эх сурвалжуудаас авсан тоо баримт, газрын зураг болон график зэргийн хоёрдогч эх үүсвэрийн мэдээллийг нягтлан шалгасан ;
- Төслийн талбайн дээжлэлтийн хөтөлбөр ба судалгаагаар хийсэн гадаргуун ба гүний усны чанар ба тоосны хэмжилт, амьтны аймгийн судалгаа ба ургамлан бүрхэвчийн судалгаа зэргээс цуглуусан мэдээллүүд;
- Сумын төвийн байнгын оршигч иргэд болон төслийн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа малчидтай хийсэн ярилцлагуудын үр дүнд олж авсан нотолгоо;
- БОАЖЯ-ны шаардлага болон олон улсын стандартын дагуу Оюу Толгой ХХК-аас хэрэгжүүлсэн хяналт шинжилгээний хөтөлбөрүүд; ба
- Лабораторийн шинжилгээ.

Хамгийн сүүлийн байдлаар, энэхүү БОННБҮ-ний хүрээнд хийгдсэн нэмэлт үйл ажиллагаануудыг (суурь судалгаа ба нөлөөллийн үнэлгээнд аль алинд нь хамааралтай) хэрэгжүүлж байна. Үүнд:

- Тоосны загварчлалын үр дүн (QA/QC) дахин үнэлгээ хийх;
- Сүүлийн төлөвлөлт болон зураг төслийг харгалзан, уурхайн лицензий талбайн хий ялгаруулалт болон тоосжилт зэргийн агаарын тархалтын загварчлалыг боловсруулах ажлыг үргэлжлүүлэх;

- Уур амьсгалын боломжит өөрчлөлтийн хувилбаруудыг ба түүний Оюу Толгой төсөлд үзүүлэх нөлөөллийг загварчилна;
- Төслийн хүлэмжийн хийн бүртгэлийг бэлдэх ;
- Мэдрэмтгий хүлээн авагчдын байршлыг харгалзан үзсэн дуу чимээний суурь судалгаа;
- Хаягдал хадгалах байгууламж болон хаягдал чулуулгын овоолго зэргийн зураг төсөл ба менежментэд Нийгэм, байгаль орчны суурь судалгааны мэдээллийг харгалзан үзэх;
- Төслийн бүсэд байгаа нүүдлийн амьтдын амьдралын хэв маяг ба түүний Оюу Толгой төсөлд үзүүлэх харилцан үйлчлэл зэргийг тодорхойлох урт хугацааны судалгааг эхлүүлэх ;
- Нүүлгэн суурьшуулалтын төлөвлөгөөг боловсруулах ба нүүлгэн суурьшуулалтын үйл ажиллагааны үр дүнг үнэлэн баримтжуулах өрхийн судалгаа/ иж бүрдэл аудитийг хийх.

3.4.4 Нийгмийн суурь мэдээллийн эмхтгэл

2008 онд явуулсан *Өмнөговь Аймгийн Нийгэм, Эдийн Засаг, Байгаль Орчны Суурь Судалгаа* /ӨНБОСС/ Оюу Толгой ХХК-аас санхүүжүүлсэн бөгөөд энэ нь Монгол улсад хийгдсэн ийм төрлийн анхны судалгаа байсан⁵. Уг судалгааг аймгийн түвшинд Монгол улсын засаг захиргаанд мэдээлэл болгон ашиглах зорилгоор хийсэн юм. Үр дүн нь аймгийн ард иргэд болон Оюу Толгой төслийн дараагийн шатны хэрэгжүүлэх тооны үйл ажиллагаануудад ашиглагдаж болохуйц маш сайн мэдээллийн сан болсон.

Уг суурь судалгаа нь маш том газар нутгийг хамран хийгдсэн тул Оюу Толгой төслийн хувьд төслийн шууд нөлөөллийн бүсэд хэрэглэхэд зохимжгүй байсан. Дээрх судалгаан дээр үндэслэн Оюу Толгой ХХК-аас төслийн нөлөөллийн бүсэд, ялангуяа Ханбогд, Баян-Овоо, Цогтцэций, Манлай, Даланзадгад зэрэг хөрш сумдад анхаарлаа хандуулан Нийгэм-эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээг хийсэн⁶. ӨНБОСС-г Оюу Толгой Нийгэм-эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээг боловсруулахад ашиглах илүү нарийвчилсан суурь судалгаа⁷ (Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засаг, байгаль орчны судалгаа (дэд багц) нэртэйгээр)-г хийхэд ашигласан юм. Тус Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан нь уурхайн барилга байгуулалт ба үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нийгэм эдийн засгийн нөлөөлөл, нийгэм эдийн засаг, байгаль орчны нөлөөллүүдийн харилцан хамаарал болон төслийн нөлөөллийн бүсэд хэрэгжих бусад уул уурхайн төслүүдээс үүсэх хуримтлагдах нөлөөлөл зэргийг авч үзсэн.

3.4.5 Нөлөөллийн ангилал ба зэрэглэл

Нөлөөллийн үнэлгээг дэс дараалалтай хийхийн тулд нөлөөллийн зэрэглэлийг тогтоох доорхи шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэнэ:

- **Хугацаа:** Богино, дунд, урт хугацаатай.
- **Хамрах хүрээ:** зөвхөн бага хэмжээний орон нутгийн шинж чанартай, өргөн хүрээний орон нутгийн шинж чанартай, хязгаарлагдмал ба өргөн хүрээнд тархсан.
- **Магадлал:** Магадлал маш багатай, Магадлал багатай, Магадлалтай, Гарцаагүй.

Нөлөөллийг эерэг ба сөрөг гэж ангилах нөлөөллүүд нь доорхи 5 ангилалын нэгд нь багтана:

- **Эерэг:** Нөөц болон хүлээн авагчид ашигтай эсвэл эерэг нөлөө үзүүлэх;
- **Маш бага (Сөрөг):** Богино хугацааны/зөвхөн орон нутгийн шинж чанартай/магадлал маш багатай;

⁵ Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тамгийн Газар, Өмнөговийн Хөгжил Судалгааны Сан. Өмнөговь аймгийн Нийгэм Эдийн Засгийн Суурь Судалгаа, 2008. www.umnugovi.mn

⁶ Оюу Толгой төслийн Нийгэмд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ, Эцсийн тайлан, Бодлого Судлалын Төв, Хүн Амын Сургалт, Судалгааны Төв, Улаанбаатар хот, Монгол улс, 2009 оны 9-р сар.

⁷ Оюу Толгой төслийн Нийгэм, Эдийн Засаг, Байгаль Орчны судалгаа (дэд багц), Эцсийн тайлан, Бодлого Судлалын Төв, Хүн Амын Сургалт, Судалгааны Төв, Улаанбаатар хот, Монгол улс. 2009 оны 9-р сар.

- **Бага (Сөрөг):** Богино буюу дунд хугацааны нөлөөлөл/ орон нутгийн шинж чанартай/ магадлал багатай;
- **Дундаж (Сөрөг):** Дунд хугацааны нөлөөлөл/ хязгаарлагдмал байдалтай/ магадлалтай;
- **Их (Сөрөг):** Урт хугацааны нөлөөлөл/ өргөн хүрээг хамарсан/ гарцаагүй буюу магадлалтай ангилалд багтана. Мөн, төслийн стандартыг зөрчиж байгаа сөрөг ба их сөрөг нөлөөллүүд үүнд бас багтана.

Нөлөөллийн үнэлгээний зэрэглэл нь Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний багийн үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын өргөн хүрээний мэдлэг, туршлагад үндэслэн хийгддэг.

Бүлэг тус бүрийн төгсгөлд цуврал хүснэгтүүдэд нөлөөллүүдийг үнэлгээний стандарт шалгуурын дагуу нэгтгэн үзүүлсэн байгаа. Тухайн арга нь боломжтой тохиолдолд, нөлөөллийн тоон хэмжээг тодорхойлох ба дундаж буюу их гэж ангилагдсан сөрөг нөлөөллүүдийг тодотгох зорилготой.

3.4.6 Бууруулах арга хэмжээ болон хяналт шинжилгээний төлөвлөлт

Олон улсын аж үйлдвэрийн тэргүүлэх туршлагаудад нийцсэн нөлөөлөл бууруулах арга хэмжээг⁸ төслийн төлөвлөлтөд тусгаж өгсөн бөгөөд энэ төслийн барилга, үйлдвэрлэл болон хаалтын үйл ажилгаануудын туршид хэрэгжих юм. Үүсэх нөлөөлөл бүрт, авах алхам ба хийгдэх ажлуудыг тодорхойлсон нөлөөлөл бууруулах арга хэмжээг бэлтгэсэн байдаг. Эдгээр бууруулах арга хэмжээнүүдийг төслийн эхэн буюу барилгын үе шат, үйлдвэрлэл, хаалтын гэх мэт үе шат бүрт тус тусад нь төлөвлөн хэрэгжүүлэх юм. Мөн сөрөг нөлөөллийг бууруулах ба менежментийн арга хэмжээнүүдээс гадна, энэхүү БОННБҮ-ний Хэсэг D-т тусгасан Менежментийн төлөвлөгөөнд төсөл хэрэгжих хугацааны туршийн үлдэгдэл нөлөөллийн менежмент хийх арга замуудыг тусган оруулсан. Нөлөөллийг бууруулах арга хэмжээг доор байдлаар шатлан хэрэгжүүлнэ:

- Нөлөөллөөс зайлсхийх эхний төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нөлөөллөөс ангид байхаар төлөвлөх;
- Боломжит хувилбаруудыг үнэлэн, боломжтой бол арай бага хэмжээний нөлөөлөл үзүүлэх арга хэмжээг сонгон авах;
- Үлдэгдэл нөлөөллийг бууруулахын тулд анхны төлөвлөгөөгөө өөрчлөн сайжруулах;
- Үлдэгдэл нөлөөллийг зохицуулахын тулд нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэглэх;
- Дээрх үе шатуудыг хэрэгжүүлсний дараа үлдэгдэл нөлөөллийг арилгахад чиглэгдсэн шударга нөхөн төлбөрийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах.

3.4.7 Байгаль орчин ба нийгмийн менежментийн систем

Энэхүү БОННБҮ-нд Оюу Толгой ХХК-ний байгаль орчны хяналт шинжилгээ ба тайлагналтын нийгэм, байгаль орчны менежментийн зохион байгууллагын бүтцийг тодорхойлсон. Оюу Толгой ХХК-ний зохион байгуулалтын бүтцийг тусгасан Байгаль орчны менежментийн систем нь Байгаль орчны хэлтсийн байгаль орчны ажлын гүйцэтгэлийн хяналт шинжилгээ болон зохицуулалтын менежментийн үндсэн хэрэгсэл нь болж байна. Үүний зэрэгцээ, орон нутгийн харилцаа ба тогтвортой хөгжлийн хэлтэс (ОНХТХХ) нь төслийн нийгэм-эдийн засгийн нөлөөллүүдийн хяналт шинжилгээ хийн удирдахийн тулд Нийгэм-Эдийн засгийн менежментийн төлөвлөгөөг (НЭЗТ) боловсруулсан. Энэ 2 системийг энэ тайлангийн Хэсэг D: *Менежментийн төлөвлөгөө-нд* тусган оруулсан байгаа. Эдгээр хоёр хэлтсүүдийн ажил болон менежментийн төлөвлөгөө/системүүд нь харилцан нэгнийгээ дэмжсэн шинжтэй бөгөөд Оюу Толгой ХХК-ний зүгээс гол асуудал ба нөлөөллүүдийг цогц хэлбэрээр хандах зорилгоор хийгдсэн бүхнийг хамарсан Байгаль орчин, нийгмийн менежментийн системийг (БОНМС) боловсруулснаар тайланг улам бататгаж өгсөн юм.

3.4.8 Нөхөн сэргээлт ба уурхайн хаалт

Төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө нөхөн сэргээлтийн болон хаалтын төлөвлөгөөг боловсруулах нь төслийн уурхайн төлөвлөлтийн үйл ажиллагааны салшгүй хэсэг нь байдаг. Уурхайн төлөвлөлтийн

⁸ Ижил нөхцөл байдалд, ижил ажил үүрэг гүйцэтгэдэг өндөр түвшний, туршлагатай мэргэжилтнүүдээс ур чадвар, хичээл зүтгэл, боломжийг олж харах зэргийг шаарддаг. /ОУСК, ГС2/

энэхүү арга барил нь уурхайн үйл ажиллагаа нь газрыг түр зуур ашиглах тул уул уурхайн хаалтын ажиллагааг зохих ёсоор хийх нь байгалийн нөөцийг урт хугацаагаар үр дүнтэй ашиглахад хувь нэмэр оруулах юм. Энэ төлөвлөгөөг төслийн үйл ажиллагааны туршид хаалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө тогтмол хянан магадлаж байх бөгөөд ингэснээр доорх зүйлсийг тооцоолон авч үзэх хэрэгтэй болно:

- Байгаль орчны мэдрэг байдлаас хамааран уурхайн хаагдсан талбайд учрах эрсдлийн хүрээний их хэмжээний өөрчлөлтүүд;
- Анхны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын цар хүрээ ба хэмжээ буюу хүдэр олборлолт ба эрдэс боловсруулалтын системэнд гарсан батлагдсан их хэмжээний өөрчлөлтүүд;
- Агаарын хаягдал ба бусад бохирдлын зөвшөөрөгдөх хэмжээний үндэсний хууль тогтоомж болон уурхайн үйл ажиллагаа хаагдсаны дараа үйлчлэх байгаль орчны стандартуудад гарсан өөрчлөлтүүд (жишээ нь: хөрсөн дэх хүнд металлын зөвшөөрөгдөх хэмжээ; гадаргын усны эх сурвалжид хаягдах уурхайн усны чанар);
- Уурхайн хаалтын төлөвлөгөөний олон улсын тэргүүлэх туршлага (ОУСК-ын Уул уурхайн Байгаль орчин, эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны удирдамж ба ЕСБХБ-ны Европын холбооны уул уурхайн хог хаягдлын заавар зэрэг шаардлагууд 2006/12/ЕС), болон Рио Тинтогийн уурхайн хаалтын ажлын стандарт; ба
- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас үүссэн нөлөөллийг бууруулах ба нөхөн сэргээх технологи, менежментийн арга барилуудыг сайжруулан авч хэрэглэх.

Бүлэг D 21: Уурхайн хаалтын хамрах хүрээ нь монгол улсын хууль тогтоомжийн шаардлагууд, олон улсын тэргүүлэх туршлага болон Рио Тинтогийн хаалтын стандартууд зэргийг мөрдөх төслийн үүрэг хариуцлагыг тодорхойлсон. Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг Оюу Толгой төслийн монголын техник эдийн засгийн үндэслэлд тусгасан төлөвлөгөө сайжруулах зорилгоор Оюу Толгой ХХК боловсруулж байгаа.

3.5 ХУРИМТЛАГДАХ НӨЛӨӨЛӨЛ

Энэхүү БОННБҮ-нд хуримтлагдах нөлөөллийн талаар авч үзсэн. Үүнийг доорхи байдлаар тодорхойлдог:

Одоо хэрэгжиж байгаа төслүүд, хэрэгжих гэж байгаа төслүүд ба/буюу ирээдүйд хэрэгжих төслүүдээс үүсэн гарах олон тооны нөлөөллүүд нь хавсарснаар, тухайн төслийн хэмжээнд урьдчилан тооцоологдох боломжгүй⁹ их хэмжээний сөрөг буюу эерэг нөлөөллүүдийг үүсгэхийг хуримтлагдах нөлөөлөл гэнэ.

Хуримтлагдах нөлөөллүүд нь зөвхөн уул уурхайн үйл ажиллагаанаас гадна төслийн нөлөөллийн бүсэд явагдах бусад үйлдвэрлэлийн ба бүтээн байгуулалтын эдийн засгийн үйл ажиллагаа ба төслийн нөлөөллийн бүсийн хүн амын өсөлт зэргээс мөн үүсч болно. Хуримтлагдах нөлөөллийн цар хүрээг энэхүү БОННБҮ-ний *Бүлэг A1: Танилцуулга-д* тусган оруулсан.

Оюу Толгойн БОННБҮ-ний хувьд, салбар хоорондын нөлөөллүүдийн талаар бүлэг бүрт авч үзсэн байгаа. Тухайлбал, тоос нь дангаараа ард иргэдэд ноцтой нөлөөлөл үзүүлэхгүй байж болох ч, тоосны уршиг, дуу чимээний уршиг ба замын хөдөлгөөн зэргийн хосолсон нөлөөллүүд нь ноцтой хэмжээнд байж болох юм. Хуримтлагдах нөлөөллүүдийг нэгтгэсэн бүлгийг мөн энэхүү БОННБҮ-нд багтаасан.

⁹ОУСК-ын удирдамж, Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын Гүйцэтгэлийн стандартууд. 2007 оны 07.31, Прага

Орчуулгын үнэн зөв баталгаа гаргахаас татгалзах тухай

Оюутолгой төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг англи хэл дээр боловсруулж, монгол хэл рүү орчуулав.

Оюутолгой ХХК уг үнэлгээг монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, англи болон монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг уншина уу.

Оюутолгой ХХК нь орчуулгын үнэн зөв, бүрэн төгс байдлын талаар ямар нэг баталгаа гаргахгүй бөгөөд Оюутолгой ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа (Гэрээ, хэлцэл, гэм хорын дагуу буюу холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүссэн г.м) хохирлыг хариуцахгүй болно.

Та уг орчуулгын алдаа, дутагдал болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө OTESIA@ot.mn хаягаар ирүүлнэ үү.